

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Нийгмийн даатгалын сангийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2025/001-НА-СТА-ЗГТС

Цахим хуудас: www.selenge@audit.gov.mn Сүхбаатар сум 2025 он	Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын сангийн дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа Утас: 7036-3040 Цахим хаяг: Enkhtuyach@audit.gov.mn Аудитын менежер: Б.Батмөнх Утас: 7036-3036 Цахим хаяг: Batmunkhb@audit.gov.mn Аудитор: Ж.Цогт Утас: 7036-3036 Цахим хаяг: Tsogtj@audit.gov.mn
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Аудитын дүгнэлт	3-5
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5-9
3. Санхүүгийн тайлангийн тодруулга	9-12
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	9
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	10
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт	11
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	11-12
4. Аудитын тайлан	12-14
4.1 Ерөнхий зүйл	12
4.2 Материаллаг байдал	13
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	13
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	13
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	14
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	14
5. Аудитын илрүүлэлт	14-15
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл	16

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
МУЕА	Монгол Улсын Ерөнхий Аудитор
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
НДЕГ	Нийгмийн Даатгалын Ерөнхий Газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт



**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН НИЙГМИЙН
ДААТГАЛЫН ГАЗРЫН ДАРГА
С.ОТГОНЖАРГАЛ ТАНАА**

2025.09.25 № СЭА-2025/001-НА-СТА-3ГТС
танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Сэлэнгэ аймгийн Нийгмийн даатгалын сангийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан зөрчил нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Сэлэнгэ аймгийн Нийгмийн даатгалын сангийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн дараах зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 6.4.8, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.7, 20 дугаар зүйлийн 20.2.5, НДЕГ-ын даргын 2022 оны А/31 дүгээр тушаалын хавсралтаар баталсан "Тэтгэвэр тогтооход шаардагдах баримт бичгийг бүрдүүлэх, хянах журам"-ын Санамж 2, НДҮЗ-ийн 2021 оны "Журам шинэчлэн батлах тухай" 09 дүгээр тогтоолын 5.2, 5.2.3, 6.2 дахь заалтуудыг зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна. Үүнд:

- НДС-аас иргэдийн тэтгэвэр, тэтгэмжийг зөрүүтэй тооцон илүү шилжүүлсэн болон авлагыг хянах, барагдуулах үр нөлөө бүхий арга хэмжээ аваагүйгээс 2024 оны оны жилийн эцэст хувь хүнээс авах 688,261,2 мянган төгрөгийн авлага

тайлагнагдсан. Үүнээс тайлант онд 114 иргэнд 72,742.4 мянган төгрөгийн тэтгэвэр, 22 иргэнд 22,052.1 мянган төгрөгийн тэтгэмжийг тус тус илүү тооцон олгож, нийт 94,794.5 мянган төгрөгийн хувь хүнтэй холбоотой авлагыг шинээр үүсгэсэн.

- Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, хүчин төгөлдөр анхан шатны баримтыг бүрэн бүрдүүлэлгүйгээр 205,238.4 мянган төгрөгийн тэтгэвэр, тэтгэмж олгож, зөрчлийг давтан гаргасан байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд тэтгэврийн даатгалын сангаас 22,616 иргэнд 174,397,128.8 мянган төгрөгийн, тэтгэмжийн даатгалын сангаас 5,132 иргэнд 7,474,747.5 мянган төгрөгийн, ҮОМШӨ-ийн даатгалын сангаас 344 иргэнд 1,550,450.6 мянган төгрөгийн, ажилгүйдлийн даатгалын сангаас 1,729 иргэнд 2,549,406.8 мянган төгрөгийн тэтгэвэр, тэтгэмжийг тус тус олгосон байна.

Аудитын гол асуудал

Тайлант онд нийгмийн даатгалын сангийн үйл ажиллагаа, бүртгэл хөтлөлтөд программын шинэчлэл хийж, нэвтрүүлсэн “SICOS” программ нь хэрэгцээ шаардлагыг бүрэн хангаагүйгээс НДС-ийн нэгтгэсэн санхүүгийн тайлан хуулийн хугацаанд бэлтгэгдэхгүй байх, санхүүгийн тайлан зөрүүтэй илэрхийлэгдэж, удаа дараа засвар оруулах зэргээр аудит хийж гүйцэтгэхэд хүндрэл учруулсан болно.

Бусад асуудлын хэсэг

Тайлант онд 91,834,326.5 мянган төгрөгийн НДС-ийн орлого төвлөрүүлэх төлөвлөгөөтэйгөөс гүйцэтгэлээр 102,325,657.4 мянган төгрөг төвлөрүүлж, 111.4 хувийн биелэлттэй тайлагнагдсан байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	28,902,332,451.8	26,935,243,844.7
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	15,271,556,582.1	9,710,578,945.6
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	15,271,556,582.1	9,710,578,945.6
31210	Төгрөг	15,271,556,582.1	9,710,578,945.6
31211	Төрийн сангийн харилцах	127,567,125.4	-
31213	Арилжааны банк дахь харилцах	15,143,989,456.7	9,710,578,945.6
33	АВЛАГА	13,630,775,869.7	17,224,664,899.1
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	8,460,611,929.4	-
33300	Татаас, санхүүжилтийн авлага	4,454,122,747.6	4,451,462,322.6
33402	Татвар, НДШ-ын авлага /ТӨҮГ/	-	11,694,906,563.0
33500	Бусад авлага	716,041,192.7	1,078,296,013.5
33510	Байгууллагаас авах авлага	716,041,192.7	390,034,837.8
33520	Хувь хүмүүсээс авах авлага	-	688,261,175.7
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	28,902,332,451.8	26,935,243,844.7
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	1,209,373,037.9	2,079,429,092.0
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	1,209,373,037.9	2,079,429,092.0
41300	Өглөг	224,534,960.3	1,118,399,129.7
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	224,534,960.3	-
41360	Бусад өглөг	-	1,118,399,129.7
41361	Байгууллагад төлөх өглөг	-	59,572,366.2
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	-	898,201,046.4
41366	Дансны өглөг /ТӨҮГ/	-	160,625,717.2
41400	Урьдчилж орсон орлого	984,838,077.7	961,029,962.3
41410	Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөв	984,838,077.7	961,029,962.3
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	27,692,959,413.8	24,855,814,752.8
51	Засгийн газрын хувь оролцоо	27,692,959,413.8	24,855,814,752.8
51200	Хуримтлагдсан үр дүн	27,692,959,413.8	24,855,814,752.8
51210	Өмнөх үеийн үр дүн	30,686,778,255.5	26,505,593,063.8
51220	Тайлант үеийн үр дүн	(2,993,818,841.6)	(1,649,778,311.1)
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	26,902,332,451.8	26,935,243,844.7

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	324,266,543,506.1	268,633,306,472.0
11	ТАТВАРЫН ОРЛОГО	82,197,958,971.8	89,405,164,422.9
112	Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого	82,197,958,971.8	89,405,164,422.9
112001	Тэтгэврийн даатгалын шимтгэл	56,218,893,494.6	73,738,968,043.7
112002	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	5,914,168,668.3	7,813,703,133.1
112003	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	5,298,040,470.5	5,143,657,605.8
112004	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	1,199,356,786.2	2,708,835,640.3
112005	Эрүүл мэндийн даатгалын шимтгэл	13,567,409,552.2	-
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	182,793,305.4	190,235,711.4
120	Нийтлэг татварын бус орлого	182,793,305.4	190,235,711.4
120002	Хүүгийн орлого	95,614,029.1	107,766,275.7
120003	Торгуулийн орлого	-	625,500.0

120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	24,476,482.3	-
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	24,476,482.3	-
120009	Бусад орлого	59,702,794.0	81,843,935.6
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	241,885,791,229.0	179,037,906,337.8
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	19,121,832,310.1	39,723,498,587.8
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	19,121,832,310.1	39,723,498,587.8
1330	Төсвийн захирагчдаас	222,763,958,918.9	139,314,407,750.0
133002	Төвлөрүүлэх шилжүүлэг	222,763,958,918.9	139,314,407,750.0
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	327,260,362,347.7	270,283,084,783.1
21	УРСГАЛ ЗАРДАЛ	327,260,362,347.7	270,283,084,783.1
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	9,592,920.0	8,580,470.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,592,920.0	8,580,470.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	2,765,700.0
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	9,592,920.0	5,814,770.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	327,250,769,427.7	270,274,504,313.1
2132	Бусад урсгал шилжүүлэг	143,328,618,543.5	184,123,113,394.3
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	143,328,618,543.5	184,123,113,394.3
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	183,921,950,884.3	86,151,390,918.7
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	183,921,950,884.3	86,151,390,918.7
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	(2,993,818,841.6)	(1,649,778,311.1)
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)-(IV)-(V)	(2,993,818,841.6)	(1,649,778,311.1)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	336,036,339,053.7	280,554,913,320.3
11	ТАТВАРЫН ОРЛОГО	80,441,960,544.2	101,651,767,669.2
112	Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого	80,441,960,544.2	101,651,767,669.2
112001	Тэтгэврийн даатгалын шимтгэл	55,036,086,186.0	69,213,973,586.2
112002	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	5,785,174,575.9	7,224,657,613.9
112003	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	5,181,509,950.5	7,583,459,512.1
112004	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	1,168,746,085.5	2,568,443,903.5
112005	Эрүүл мэндийн даатгалын шимтгэл	13,270,383,746.4	15,061,233,053.5
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	278,035,490.6	385,830,344.2
120	Нийтлэг татварын бус орлого	278,035,490.6	385,830,344.2
120002	Хүүгийн орлого	98,610,033.7	108,099,407.8
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	179,425,456.9	-
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	179,425,456.9	-
120009	Бусад орлого	-	277,730,936.5
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	249,516,343,018.9	178,517,315,306.9
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	26,552,334,100.0	39,202,561,500.0
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	26,552,334,100.0	39,202,561,500.0

1330	Төсвийн захирагчдаас	222,763,958,918.9	139,314,753,806.9
133002	Төвлөрүүлэх шилжүүлэг	222,763,958,918.9	139,314,753,806.9
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	327,431,166,674.9	286,115,890,956.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ	327,431,166,674.9	286,115,890,956.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	9,592,920.0	346,401,656.7
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,592,920.0	8,580,470.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	2,765,700.0
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	9,592,920.0	5,814,770.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	337,821,186.7
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	337,821,186.7
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	327,471,573,754.9	285,769,489,300.1
2132	Бусад урсгал шилжүүлэг	143,549,622,870.6	183,443,972,279.1
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр тэтгэмж	143,282,991,022.5	183,443,972,279.1
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	266,631,848.1	-
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	183,921,950,884.3	102,325,517,021.0
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	183,921,950,884.3	102,325,517,021.0
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	2,555,172,378.9	(5,560,977,636.5)
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	2,555,172,378.9	(5,560,977,636.5)
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	15,271,556,582.1	15,271,556,582.1
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	15,271,556,582.1	9,710,578,945.6

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн гайлан

Код	Үзүүлэлт	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	30,687,320,704.4	30,687,320,704.4
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	(542,449.0)	(542,449.0)
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	30,686,778,255.5	30,686,778,255.5
9	Тайлант үеийн үр дүн	(2,993,818,841.6)	(2,993,818,841.6)
10	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	27,692,959,413.8	27,692,959,413.8
11	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	27,692,959,413.8	27,692,959,413.8
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	(1,187,366,350.0)	(1,187,366,350.0)
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	26,505,593,063.8	26,505,593,063.8
19	Тайлант үеийн үр дүн	(1,649,778,311.1)	(1,649,778,311.1)
20	2024 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	24,855,814,752.8	24,855,814,752.8

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	185,968,525,700.0	183,452,412,331.1	2,516,113,368.9	98.6
21	УРСГАЛ ЗАРДАЛ	185,968,525,700.0	183,452,412,331.1	2,516,113,368.9	98.6
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	23,582,700.0	8,580,470.0	15,002,230.0	36.4
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	23,582,700.0	3,580,470.0	15,002,230.0	36.4
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	9,903,300.0	2,765,700.0	7,137,600.0	27.9
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	13,679,400.0	8,814,770.0	7,864,630.0	42.5
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	185,944,943,000.0	183,443,831,861.1	2,501,111,138.9	98.7
2132	Бусад урсгал шилжүүлэг	185,944,943,000.0	183,443,831,861.1	2,501,111,138.9	98.7
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	185,944,943,000.0	183,443,831,861.1	2,501,111,138.9	98.7
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	185,968,525,700.0	125,920,949,892.7	60,047,575,807.3	67.7
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	39,202,561,500.0	39,202,561,500.0	-	100.0
310001	Улсын төсвөөс санхүүжих	39,202,561,500.0	39,202,561,500.0	-	100.0
33	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	146,765,964,200.0	86,718,388,392.7	60,047,575,807.3	59.1
330001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	146,765,964,200.0	86,718,388,392.5	60,047,575,807.5	59.1
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	15,271,556,582.1	(15,271,556,582.1)	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	9,710,578,945.6	(9,710,578,945.6)	

3. САНХҮҮГИЙН ТАЙПАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Сэлэнгэ аймгийн Нийгмийн даатгалын сан нь 2024 онд “Бид даатгуулагчийнхаа итгэл найдвар, сэтгэл ханамжаар үнэлэгдэх нийгмийн даатгалын үйлчилгээг хүргэнэ” гэсэн эрхэм зорилгын хүрээнд үйл ажиллагаа явуулсан бөгөөд үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Нийгмийн даатгалын тухай хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангах,
- Нийгмийн даатгалын хамрах хүрээг өргөтгөх,
- Нийгмийн даатгалын сангийн орлогын бүрдүүлэлтийг хангах, уг сангаас татасвэр, өртөгний төлбөрт үйлчилгээний зардлыг цаг тухайд нь олгох,
- Нийгмийн даатгалын үйлчилгээг даатгуулагч иргэдэд шуурхай чирэгдэлгүй хүргэх,
- Үйлчилгээний чанар, хүртээмж, мэдээллийн ил тод байдлыг сайжруулах,
- Даатгалын үйлчилгээнд дэвшилтэд хэлбэр, мөрдөгчлөлийг нэвтрүүлэх,
- Менежментийн чөлөөтэй бэхжүүлэх, ажилтнуудыг найдваржуулах,
- Хууль тогтоомжийг сурталчлах ажлыг шинэ шатанд гаргах гэх мэт.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- *Монгол Улсын 2024 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой*
- *Нийгмийн даатгалын ерөнхий хуульд 2024 оны 06 дугаар сарын 05-нд нэмэлт өөрчлөлт орсон,*
- *Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2024 оноос эхлэн мөрдөж эхэлсэн байна.*

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд тайлант онд НДС-ийн үйл ажиллагаанд шинээр нэвтрүүлсэн “SICOS” программ хангамж болон үйл ажиллагааны уялдаа холбооноос шалтгаалан санхүүгийн тайлан мэдээ бэлтгэгдэх явц удааширч, төрийн аудитын байгууллагад ирүүлэх хугацааг хоцроох байдалд хүргэсэн нь дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилтийн үр нөлөө сул байгааг харуулж байна.

Дотоод хяналт, шалгалтын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод хяналт, шалгалтын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Аймгийн Нийгмийн даатгалын сангийн 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл суурьд хөтөлж, нийтлэг зорилготой, үрэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагад мөрдөж байгаа Нийгмийн даатгалын сангийн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг 2022 онд боловсруулсан бөгөөд уг баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Гэвч Нийгмийн даатгалын ерөнхий хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуульд шинэчилсэн найруулга хийгдэн 2024 оны 01 дүгээр сараас эхлэн хэрэгжиж байгаа тул уг хуулиуд болон бусад хууль, эрх зүйн актуудын өөрчлөлтийг тусгах, нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинэчлэн боловсруулах нь зүйтэй юм.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Аймгийн Нийгмийн даатгалын сангийн 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2023 оны А/229 дүгээр тушаалаар баталсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

2024 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,967,088.6 мянган төгрөгөөр буюу 6.8 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	15,271,556.6	9,710,578.9	(5,560,977.6)
Авлага	13,630,775.9	17,224,664.9	3,593,889.0
Нийт хөрөнгө	28,902,332.4	26,935,243.8	(1,967,088.6)
Өр төлбөр	1,209,373.4	2,079,429.1	870,056.0
Засгийн сангийн хувь оролцоо /Эздийн өмч/	27,692,959.4	24,855,814.8	(2,837,144.6)
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	28,902,332.4	26,935,243.8	(1,967,088.6)

Дээрх хүснэгтээс харахад дараах дансанд нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна. Үүнд:

- Тайлант онд мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл өмнөх оноос 5,560,977.6 мянган төгрөгөөр буурсан нь 12 дугаар сард нийгмийн даатгалын сангаас олгогдох тэтгэврийн санхүүжилт дутуу олгогдон он дамжсанаас голлон шалтгаалсан байна.
- Авлага данс 3,593,889.0 мянган төгрөгөөр өссөн нь Болд төмөр-Ерөө гол, Хөтөл Цемент шохой зэрэг томоохон аж ахуйн нэгжүүдийн НДШ-ийн төлөлт тасарснаас голлон шалтгаалсан байна.
- Тайлант онд өр төлбөр 870,056.0 мянган төгрөгөөр өссөн нь даатгуулагчид олгох ажилгүйдлийн тэтгэмж, жирэмсэн амаржсаны тэтгэмж, хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмжийг он дамжуулан олгосноос шалтгаалсан байна.
- Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 24,855,814.8 мянган төгрөг болж 2,837,144.6 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүн болон нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтэй холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 3.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр, нийт орлогыг 57,173,745.3 мянга төгрөгөөр, зарлагыг 198,874,640.7 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлснийг төсвийн төслийн саналаас зардлыг 20,239,741.1 мянган төгрөгөөр бууруулж 178,634,899.6 мянган төгрөгөөр, орлогыг 11,465,319.5 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн 68,639,064.8 мянган төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант энд хийсэн төсвийн тодотголоор нийт орлогыг 23,195,261.7 мянган төгрөгөөр, зарлагыг 7,333,626.1 мянган төгрөгөөр нэмэгдүүлсэн байна. Төсөв захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 6 арга хэмжээг санхүүжүүлэхээр 146,765,964.2 мянган төгрөгийг нийгмийн даатгалын сангаас, 39,202,561.5 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр нийгмийн даатгалын сангаас 86 718,388.4 мянган төгрөг, улсын төсвөөс 39,202,561.5 мянган төгрөг, нийт 125,920,949.9 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 102,325,657.4 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 183,452,412.3 мянган төгрөг буюу 98.6 хувьтай байгаа нь сангаас олгосон тэтгэвэр тэтгэмжийн гүйцэтгэлтэй холбоотой байна.

Хүснэгт 8. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	71900-Нийгмийн даатгалын сан	185,968,525.7	183,452,412.3	2,516,113.4	98.6
	Нийт	185,968,525.7	183,675,276.5	2,293,249.2	98.8

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Сэлэнгэ аймгийн Нийгмийн даатгалын сангийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ж.Цогт гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Сэлэнгэ аймгийн Нийгмийн даатгалын газар нь нийгмийн даатгалын сангийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн

аудитын газарт 2025 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн 50 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2023 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардлаас тогтоосныг аудитын явцад /тайлант оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар Нийгмийн даатгалын газар болон Нийгмийн даатгалын сан гэж тусдаа дүгнэлт гарах болсон тул/ дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Иймд гүйцэтгэлийн үеийн материаллаг байдлыг 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 270,283,084.8 мянган төгрөгөөс 1.0 хувиар тооцон **2,702,830.8** мянган төгрөгөөр шинэчлэн тогтоолоо.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийг мөрдөж ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 8 дугаар зүйл, Засгийн сангийн 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан *"Шилэн дансны цахим хуудсанд тарах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"*-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд аймгийн Нийгмийн даатгалын сангийн мэдээлбэл зохих 28 төрлийн 171 мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тайлант онд бусад хууль, тогтоомжийн хэрэгжилтэд хамаарах алдаа, зөрчил илрээгүй.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын 2024 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 173 дугаар “Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх тухай” албан бичгийг хүргүүлсэн бөгөөд завсрын үеийн аудит хийгдээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 184 073.3 мянган төгрөгийн зөрчилд зөвлөмж хүргүүлснийг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	1	184,073.3			
Нийт дүн	1	184,073.3			

/мянган төгрөгөөр/

Шийдвэрлэсэн нь: Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй учир албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал гараагүй болно.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 203,236.4 мянган төгрөгийн 2 зөрчилд¹ албан шаардлага хүргүүлэв.

5.1 Албан шаардлага:

1. Тооцооллын алдаанаас шалтгаалан НДС-аас иргэдийн тэтгэвэр тэтгэмжийг зөрүүтэй тооцон илүү шилжүүлсэн болон үүссэн авлагыг хянах, барагдуулах үр нөлөө бүхий арга хэмжээ аваагүйгээс 2024 оны оны жилийн эцэст хувь хүнээс авах 688,261,2 мянган төгрөгийн авлага тайлагнагдсан байна. Үүнээс тайлант онд 114 иргэнд 72,742.4 мянган төгрөгийн тэтгэврийн, 22 иргэнд 22,052.1 мянган төгрөгийн тэтгэмжийг илүү тооцон олгож, нийт 94,794.5 мянган төгрөгийн хувь хүнтэй холбоотой авлагыг шинээр үүсгэсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь “Төсвийг зохистой удирдаж, авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь “Дансны өглэг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ...” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон саламсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Шийдвэрлэсэн нь: Хувь хүнтэй холбогдох тооцоог урьдчилан хянаж, авлага, үүсгэхгүй ажиллах, үүссэн авлагыг барагдуулах үр нөлөө бүхий арга хэмжээ авах албан шаардлага хүргүүлэв.

2. Аудитын явцад Мандал, Сайхан, Сүхбаатар сумдын өндөр насны, тэжээгчээ алдсаны, тахир дутуугийн тэтгэвэр, ажилгүйдлийн тэтгэмж олголтыг түүвэрлэн шалгахад хувийн хэргийн бүрдлийн шаардлагыг хангаагүй баримт, материалыг үндэслэн **110,443.9** мянган төгрөгийн тэтгэвэр, тэтгэмжийг тооцож олгосон байна. Үүнд:

- **Өндөр насны, тэжээгчээ алдсаны, тахир дутуугийн тэтгэвэр:**

Тэтгэврийн хувийн хэрэгт иргэний үнэмлэх, төрүүлсэн болон үрчлэн авсан хүүхдийн төрсний гэрчилгээний мэдээллийг төрийн мэдээллийн “Хур”системээс авалгүйгээр хуулбарыг хавсарган нийт **50,735.4** / Мандал сум – 23,076.8, Сайхан сум – 8,054.0, Сүхбаатар сум – 19,604.6/ мянган төгрөгийн тэтгэврийг тооцож, олгосон байна.

Энэ нь НДЕГ-ын даргын 2022 оны А/31 дүгээр тушаалын хавсралтаар баталсан “Тэтгэвэр тогтооход шаардагдах баримт бичгийг бүрдүүлэх, хянах журам”-ын Санамж 2-т “Нийгмийн даатгалын байгууллага (байцаагч) нь тэтгэвэр тогтоолгох хүсэлт гаргасан даатгуулагч (иргэн)-ийн энэ журмын 2.1.2, 2.1.9-д заасан баримт бичгийг **төрийн мэдээлэл солилцооны “ХУР” системээс, ... авна**” гэж заасныг зөрчсөн байна.

- **Ажилгүйдлийн тэтгэмж:**

Тэтгэмжийн хувийн хэрэгт олголт хийсэн тухай бүр тэмдэглэгээ хийлгүйгээр болон ажлаас халсан тухай шийдвэрийн эх хувийг бус хуулбарыг хавсарган нийт **59,708.5** /Мандал сум – 29,790.8, Сайхан сум – 14,050.0, Сүхбаатар сум – 15,867.7/ мянган төгрөгийн тэтгэмжийг тооцож, олгосон байна.

Энэ нь НДҮЗ-ийн 2021 оны “Журам шинэчлэн батлах тухай” 09 дүгээр тогтоолын 5.2-т “Ажлаас халагдсан ... 5.2.3: **Ажлаас халсан тухай шийдвэр, ...**”, 6.2-т “**Даатгуулагчид олгосон тэтгэмжийн хэмжээг сар бүр тэтгэмж олгох тухай мэдэгдэл, ажилгүйдлийн даатгалын сангийн харилцах дансны баримттай тулган шалган, баталгаажуулж, тэтгэмжийн олголтыг түүний хувийн хэрэгт тухай бүр тэмдэглэнэ**” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Эмнэх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэлгүйгээр тэтгэвэр, тэтгэмжийн хувийн хэрэгт хүчин төгөлдөр баримт, бичгийг холбогдох журамд заасны дагуу бүрдүүлж, хавсаргаагүй, тэтгэмж олгосон тухай бүр хувийн хэрэгт бичилт хийгээгүй зөрчлийг давтан гаргасан тул албан шаардлага хүргүүлэв.

Аудитын явцад бичдэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Хувь хүний тэтгэвэр, тэтгэмжийн тооцооллоос шалтгаалан авлага үүсгэсэн/ тайлант жил шинээр үүссэн/	1	94,794.5			1	94,794.5						
Хүчин төгөлдөр анхан шатны баримтыг бүрэн бүрдүүлэлгүйгээр тэтгэвэр, тэтгэмж олгосон	1	110,443.9			1	110,443.9						
Дүн	2	205,238.4			2	205,238.4						